



Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх
Ерөнхийлөгч
Даллин Х.Өүкс

Есүс биднийг хайрладаг шиг бусдыг хайрлах нь



Есүс Өөрийн шавь нарт “Би та нарыг яаж хайрласан шиг та нар бие биеэ хайрлагтун” (Иохан 15:12) гэсэн нэгэн чухал зарлигийг өгчээ. Бид Христийн дагалдагчдын хувьд бусадтай хамт амар амгалан амьдрах хэрэгтэй. Үүнд бидэнтэй адил зүйлд итгэдэггүй хүмүүс ч багтана.

Аврагч биднийг хайрладаг шиг бид бусдыг хайрлаж болох хэд хэдэн арга замыг энд оруулав. Үүнд:

- Өөрөөсөө өөр хүмүүст сайхан сэтгэлээр ханд.
- Тэдний итгэл үнэмшилд хүндэтгэлтэй ханд.
- Хэнийг ч дээрэлхэж эсвэл дорд үзэж болохгүй.

- Сайн сонсогч бай.
- Эелдэг бай. Уурлан маргалдаж болохгүй.
- Үнэний төлөө зогс.
- Бусдад сайн мэдээний талаар даруу байдлаар хэл. “Үнэнийг хайраар [ярь]” (Ефес 4:15).

Аврагч биднийг хайрласан шиг бие биенээ хайрлах тушаал бол магадгүй хамгийн агуу сорилт байж болно. Бид хийж байгаа бүхнээрээ хайраа харуулах болтугай гэж би залбирч байна. ●

Даллин Х.Өүкс, “Бусдыг хайрлаж, өөр үзэл бодол бүхий хүмүүстэй хамт амьдрах нь,” 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 27–30.